


Айвенхоу майнз монголия инк компани

Өмнөговь аймгийн Ханбогд сумын засаг
дарга Д. Буянтогтох
Байгаль орчны байцаагч
Санжмятав



БАЙГАЛЬ ОРЧИНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
2004 он

Улаанбаатар хот

**ОЮУ ТОЛГОЙ, МАНАХТ, ХӨХ ХАД, УЛААН УУЛЫН
ТАЛБАЙНУУДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ТӨСЛИЙН УРЬДЧИЛСАН ТОДОРХОЙЛОЛТ
/ 2004 оны 1 дүгээр сар /**

Нэг Ерөнхий мэдээлэл

1,1 Төслийн нэр

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюутолгойн талбайд хийх геологийн нарийвчилсан судалгааны ажил

1,2 Төслийн зорилго

Оюу толгой, Манахт, Хөх хад, Улаан уулын лицензийн талбайн геологи структурын онцлогийг нарийвчлан судлах, хүдрийн эрдсүүдийн тархалтын зүй тогтол болон прогнозын нөөцийг тодорхойлох, ордыг олборлох технологи боловсруулахад шаардагдах нэмэгдэл мэдээлэл цуглуулах.

Зэсийн илэрлийн / хойт, төв болон өмнөд Оюу Толгойн орчимд / буюу тус компанийн 66Х тоот хайгуулын лицензийн талбайд хүдрийн биетээс технологийн сорьцлолын дээж авах, эрдсийн нөөцийн тооцоо, үнэлгээний нарийвчлалыг өсгөх зорилгоор хайгуулын далд малталтын ажлыг 2004 оны эхээр хийхээр төлөвлөж байна. Далд малталт хийх ажлын байгаль орчины төлөвлөгөөг 2-р хэсэгт дэлгэрэнгүй хийж тусгав.

1,3 Төслийн эцсийн бүтээгдэхүүн

Оюу толгойн талбайд хийсэн геологийн зураглал судалгааны ажлын тайлан, ордын нөөцийн тайлан.

1,4 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Төслийг Айвенхоу Майнз Монголия Инк. Компани хэрэгжүүлнэ.
Сүхбаатар дүүрэг, Их засаг өргөн чөлөө, 6-р байрны 3-р давхар
Утас 976-11 – 310785, 312289, 310775
Факс 976- 11- 312337 Email Tuyan@ivanhoemines.mn

1.5 Тоног төхөөрөмж / үндсэн /

Компани өөрийн лицензийн талбайнуудад хийх геологийн судалгааны ажлыг тус компанийн геологчид болон гэрээгээр ажиллах 3 голлох компанийн хүчээр хийхээс гадна Энэ ажилд гадаад дотоодын лабораториуд, зөвлөх компаниуд оролцоно. Оюу толгойн ордын талбайд 2004 онд нийт 200 цэгт нийтдээ 1000 алмазан өрөмдлөг, Манахт, Хөх хад, Улаан уулын талбайд геологийн маршрутын судалгаа хийх юм. Геологийн судалгааны явцад чулуулгийн гарш, хөрс, кернээс авсан сорьцуудад геохимийн шинжилгээ хийлгэнэ. Геологийн судалгааны нийт ажлын хэмжээг 2004 оны хайгуулын ажлын төлөвлөгөөний төслөөс үзнэ үү.

1,6 Дэд бүтэц /ашиглагдаж буй /

Байхгүй

1.7 Тухайн бүс нутагт хэрэгжиж буй болон хэрэгжих бусад төсөл

Энэ бүс нутагт Монгол газар зэрэг хэд хэдэн компани геологи хайгуулын төсөл хэрэгжүүлж буй мэдээ бий. Тус компани Оюу толгойн талбайгаас гадна хуучин энэ лицензийн талбайн хүрээнд байсан Хөх хад, Манахт, Улаан уулын талбайнуудад хайгуулын ажил явуулна.

1.8 Төслийн хэрэгжилтийн урьдчилсан хуваарь – график

Дээрх талбайд хийхээр төлөвлөсөн ажлаа 2004 оны эхээр эхэлж 11-12 сард дуусгана. Геологийн судалгааны төлөвлөгөөнд ямар нэгэн гол өөрчлөлт орох тохиолдолд холбогдох агентлаг, болон байгаль орчины яаманд мэдэгдэнэ. Оюу толгой ордын байгаль орчины нарийвчилсан үнэлгээг Эко-трейд компани хийж байгаа ба энэ онд батлуулахаар өргөн барина. Байгаль орчины нарийвчилсан үнэлгээг Байгаль орчины яамнаас 2003 оны 3-р сард гарсан заавар, журмын дагуу хийж байна.

Хоёр. Эдийн засгийн үзүүлэлтүүд

2.1 Хөрөнгө оруулалт

Тус компани энэ талбайнуудад 2004 онд нийтдээ өрөмдлөг болон усны эрэл хайгуулын цооногуудыг нөхөн сэргээхэд 2,5 мянган доллар зарцуулахаар төлөвлөж байна. Үүний усны судалгаанд гүний хоолой, наран загт 10 цооног, галбын говьд 16 цооног өрөмдөхөөр төлөвлөж байна. Төлөвлөсөн өрөмдлөгийн ажлыг технологийн дагуу явуулахын тулд нэг цооног дээр 72м3 багтаамжтай өрмийн зумпуудыг малтана. Эдгээр усны зумпуудыг нөхөн сэргээхэд

1. $26 * 72м3 * 524,8$ тугр 982,425 тугр зарцуулна.

2. $55 * 72м3 * 262,4 = 1039104,0$ тугр зарцуулна.

Нийт усны цооног өрөмдөх зардлыг тооцоолбол:

$7809 \text{ п/м} * 300,0 \text{ долл} = 2342700,0 \text{ долл}$

3. Геологи, хайгуулын өрөмдлөгийн зумпуудыг нөхөн сэргээхэд

$200 * 5м3 * 524,8$ тугр = 524800,0 тугр

Нийт зумпыг булахад шаардагдах хөрөнгө

$982,425 + 1039104,0 + 524800,0$ тугр = 2546329 тугр

Орчныг тоосжилтоос хамгаалж, уурхай отвалын замуудыг тогтмол усалж байх

4. зардалд 600000,0 тугр

5. Хог хаягдлын зайлуулт, цэвэрлэгээний ажилд 853671,0 тугр

6. 2004 оны нийт байгаль орчныг хамгаалах зардал

$1+2+3+4+5 = 4,0$ сая тугр

2.2. Үйлдвэрлэлийн зардал

Үйлдвэрлэлийн зардал дараах /ажилчдын цалин, лицензийн төлбөр, хайгуулын анги тээвэр, байгаль орчны хамгааллын зардал оролцон / гарна.

2.3. БОХ арга хэмжээний нийт зардал

No	Bore	Contractor	Eastings	Northing	SWL	Est. ID	Plain Interval	Total Plain	Slotted Interval	Total Slotted	Total Casing
1	GGW1	Pentel	691220	4723300	10.09	230	0.33 143.159.5	33 16.5	33-143 159.5-214	110 51.5	214
2	GGW2	Pentel	691220	4723300	0.5	352	0.39	39	39.350	31.1	350
3	GGW3	Pentel	691220	4723300	0.93	244	0.31 91.5-122 243-254	34 27.5 11	34.91.5 122-243	60.5 121	254
4	GGW20	Pentel	691220	4723300	6	272	0.99 198-225.5	99 27.5	99-198 225.5-269.5	99 44	269.5
5	GGW11	Pentel	691220	4723300	37	343	0.93.5 159.5-198	93.5 58.5	93.5-159.5 198-341	66 143	341
6	GGW21	Pentel	691220	4723300	16.58	315	0.77 192.5-291.5	77 99	77-192.5 291.5-311.5	115.5 22	313.5
7	GGW25	Pentel	691160	4735800	61	304	0.77	77	77.312.5	225.5	302.5
8	GGW32	Pentel	691340	4741620	17.6	222	0.21.5	27.5	27.5-220	192.5	220
9	GGW19	Pentel	700210	4750000	17.5	332	0.33 60.5-99	33 38.5	33-60.5 99-330	27.5 231	330
10	GGW18	Pentel	705000	4742000	34	289	0.44 132-170.5	44 38.5	44-132 170.5-297	88 125.5	297
11	GGW28	Pentel	718000	4751000	21	191	0.41 79.5-101.5	41 21.5	41-79.5 101.5-180.5	38.5 48	189
12	GGW42	Pentel	739000	4774000		300		75		225	300
13	GGW43	Pentel	737000	4778700		300		75		225	300
14	GGW44	Pentel	748000	4772000		300		75		225	300
15	GGW45	Pentel	743000	4786000		350		105		245	350
16	GGW46	Pentel	755000	4798000		350		105		245	350

No	Bole	Contractor	Easting	Northing	SWL	Fst ID	Interval	Total Flamm	Interval	Slotted	Casing
1	GHW14x1	Zarubs	67280	4790700	22	255	0-23 60.5-101.5	33	33-60.5	27.5	253
	GHW2x3	Zarubs	662060	4785060	24	275	0-11.5 53.141 146.5-174 251-252	44 88 27.5	101.5-253 14.5-253 141-196.5 174-251	148.5 38.5 5.5 77	
3	GHW5x1	Zarubs	677490	4794560	58.1	320	0-93.5	41	262-257	11	273
4	GHW6x1	Zarubs	682393	4799540	57.8	255	0-60.5	93.5	93.5-319	225.5	319
5	GHW14x1	Zarubs	683200	4803000		350		60.5	60.5-253	192.5	253
6	GHW15x1	Zarubs	697450	4800500		350		105		245	350
7	GHW15x2*	Zarubs	698400	4815000		350		105		245	350
8	GHW7x1*	Zarubs	700000	4805000		300		75		225	300
9	GCW40*	Zarubs	724552	4778530		300		75		225	300
10	GCW41*	Zarubs	731794	4768070		300		75		225	300

Хээрийн судалгааны явцад хайгуулын ангийн үйлчилгээ, геологийн судалгаанд ашиглагдах машин техникүүд нь одоогийн гаргасан хуучин замуудыг ашиглах тул үүсэх газрын эвдрэл бага гарна. Нийт гаргасан замын хэмжээ 100 км .

Харин өрөмдлөгийн ажлын үед өрмийн болон үйлчилгээний том машин механизм ажиллан газрын хөрс болон хэвлийг хөндөх тул Оюу толгойн байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлнэ. Оюу толгойн талбайд өрөмдөх усны 26 цооногийн байгаль орчныг цэвэрлэн нөхөн сэргээхэд 982000 орчим төгрөг шаардагдана.

Оюу Толгой дахь геологи судалгааны байгаль орчины нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг монголын үнэлгээний ЭКО ТРЭЙД компани хийж, 2004 онд хийж дуусган батлуулахаар төлөвлөж байна.

2.4 БОХ арга хэмжээний жилийн зардал

БОХ арга хэмжээнд 2004 онд 4,0 сая төгрөг зарцуулна. Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 11-р заалтын дагуу байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгож холбогдох сум дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд нийт төсвийн 50 хувийг хийнэ.

Тус компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний тухайн жилийн ажлыг хийж гүйцэтгэсний дараа барьцааны мөнгийг эргүүлэн авна .

2.10 Байгаль орчин бохирдуулсны төлбөр ,хураамж

Монгол улсын хуулийн дагуу гэрээ хийж,тээврийн хэрэгслийн төлбөр, газар эзэмшисний төлбөр, ус ашигласны төлбөрийн тооцоог холбогдох хуулийн дагуу хийнэ. Энэ нь нийт 2003 оны жишиг тооцоогоор 6,0 сая төг болно.

Гурав. Төслийн үйл ажиллагаа ,техникийн шийдлийн асуудал

3.1 Төслийн үйл ажиллагаа / технологийн / - ны бүдүүвч, схем

Оюу толгой ,Манахт,Хөх хад, Улаан уулын талбайнуудад хийх хайгуул судалгаа , өрөмдлөгийн ажлын явцад чулуулгийн гарш, цооног дээр ажиглалт ,бичиглэл хийх ба байрлалыг - ээр тогтооно. Энэ мэдээллийг ашиглан геологийн зураг схем зохионо.

3.2 Түүхий эд, туслах материал

а/ Байгалийн баялаг

Оюу толгой,Манахт,Хөх хад,Улаан уулын талбайд геологи ,өрөмдлөгийн ажил хийх хайгуулын анги ойролцоогоор 460 хүн 360 хоног ажиллана. Энд ундны болон ахуйн хэрэгцээний усыг нэг хүнд 50л/хоног ,өрөмдлөгт хоногт 8м3 байхаар авав.

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Цэвэр ус	165600 хүн/ өдөр*0,05м3 = 8280 м3	Худаг, булаг
Өрөмдлөгийн ус	1200өрөм/өдөр*5м3= 6000м3	Худаг,булаг

3.3 Хог хаягдал ,завсрын бүтээгдэхүүн

а/ Завсрын бүтээгдэхүүн

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Байхгүй		

б/ Хатуу хог хаягдал

Нэр төрөл	Хэмжээ	Эх үүсвэр
Лааз,шил,яс	2 тонн	Хүнсний зүйлсийн сав

в/ Шингэн хаягдал

Нэр төрөл	хэмжээ	Эх үүсвэр
Ахуйн бохир ус	1070м3	Гал тогоо,шүршүүр,жорлон

Дөрөв. Хог хаягдлын хяналт, удирдлага зохион байгуулалт

4.1 Хог хаягдал цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр

а/ Хатуу хог хаягдал

Нэр төрөл	Цэвэрлэгээ	зайлуулалт
Лааз,шил,яс	байнга	Хаягдалын цэгт өгөх

б/ шингэн хаягдал

Нэр төрөл	Цэвэрлэгээ	зайлуулалт
Ахуйнбохир ус/шүршүүрийнус,гал тогоо,жорлон /	байнга	Бохир ус зайлуулах цэгт

4,2 Цацраг идэвхт хог хаягдал түүний цэвэрлэгээ

Нэр төрөл	Цэвэрлэгээ	зайлуулалт
Байхгүй		

Тав. Нийгмийн асуудал

5.1 Ажиллах хүчний тоо, мэргэжлийн ангилал,шаардлага

Тус компанийн хайгуулын ангид ангийн дарга,геологчид,тогооч,жолооч нар ба гэрээгээр ажиллаж байгаа компанийн ажилчид багтана.

5.2 Ажиллах хүчний эх үүсвэр

Тус компанийн гадаад дотоодын эксперт мэргэжилтнүүд болон гэрээгээр ажиллах компанийн ажилтан ажилчидаас бүрдэнэ.

5.3 Ажиллагсадын нийгмийн асуудлын шийдвэрлэлт

Компани хээрийн үйлдвэрлэлийн үед ажиллагсадыг өдөрт гурван удаа халуун хоолоор ханган бүх ажилд өөрийн унаагаар үйлчилж түр орон сууц,телефон холбоогоор бүрэн хангана. Хайгуулын ангийн төвд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх тоног төхөөрөмж, эм бэлдмэлээр бүрэн хангагдсан нэг их эмч байнга ажиллана. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу ажиллагсадын эрүүл мэнд , нийгмийн болон бусад даатгалыг хариуцана.

Зургаа. Төсөл хэрэгжих газар нутгийн суурь нөхцөл байдал

Хүн ам сийрэг нутагладаг,аймаг болон сумын төвөөс алс зайдууд,дэд бүтэц буурай хөгжсөн , зам харгүй муутай газар оршдог.Оюу толгой Ханбогд сумын төвөөс 45 км зайтай . Сумын төвд эмнэлэг , холбооны салбар , дэлгүүр,шатахуун түгээх газартай.

6.1 Агаарын бохирдлын асуудал / үндсэн үзүүлэлтээр /

Агаарын бохирдол байхгүй боловч ерөнхийдээ хуурай, шороон шуурга их шуурдаг,тоос нилээд ихтэй.

6.2 Усны бохирдлын асуудал / гүний болон гадаргын усны үндсэн үзүүлэлтээр /

Газар доорх ус нь бохирдол байхгүй боловч бага гүнтэй, усны төвшин худгууд нь малын шивтрээр бага зэрэг бохирдсон, ихэнх худгийн ус эрдэсжилт нилээд өндөр учир ундаанд хэрэглэхэд тохиромж муутай. Иймд ундны усны шинжилгээг тогтмол хийж байна.

6.3 Хөрсний бохирдлын асуудал

Худгуудын ойролцоох газруудын хөрснөөс бусад хөрс бохирдол байхгүй. Хүний үйл ажиллагаанаас нөлөөлсөн эвдрэл байхгүй.

6.4. Цаг уурын үндсэн үзүүлэлтүүд

Хавар салхи ихтэй, үе үе ширүүсэн шороогоор шуурдаг. Зун нь хамгийн их халуун +36С хүртэл халуун, өвөлд хамгийн их -31С градус хүртэл хүйтэрдэг, жилд дунджаар 80 мм тунадас унадаг.

6.5 Газар зүйн / геологийн тогтоц/ үндсэн тодорхойлолт

Дээрх талбайнууд нь физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаардаг, газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтдаг байна. Геологийн хувьд уг талбай нь 1:200000 масштабтай геологийн зургаар бүрэн зарим хэсэг нь 1-50000 масштабтай геологийн зургаар бүрхэгдсэн байгаа..

6.6 Газар эдэлбэрийн хэлбэр

Байгалийн онцлог байдлаас шалтгаалан газар тариалан хөгжүүлэх боломжгүй, харин малын бэлчээрт ашиглах боломжтой.

6.7 Ургамалын аймаг

Ургамал газрын хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд тачир сийрэг ургадаг боловч тэжээллэг чанар сайтай. Ихэвчлэн бутлаг ургамал ургана. Хонхор буюу сайрын хоёр талаар хайлаас ургах ба агь шарилж, харгана цав толгодыг бүрхэнэ. Нам дор, хотгор газруудаар дэрс ургана.

Ойн бүрхэвч байхгүй боловч том сайруудын дагуу хайлаас ургадаг.

6.8 Ойн бүрхэвч

Ойн бүрхэвч байхгүй боловч том сайруудын дагуу хайлаас ургадаг

6.9 Соёл, шинжлэх ухааны дурсгал

Одоогоор Оюу толгойн орчимд 2001-2002 онд хийсэн архелогийн судалгааны явцад эртний соёл иргэншлийн үлдэгдэл, соёл шинжлэх ухааны холбогдолтой нилээд олон газар байгаа нь илэрсэн байна. Эртний энэ ухмалууд нь одоогоос 5,000-6,000 мянган жилийн тэртээд ашиглагдаж байжээ.

6.10 Нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, бүтэц

Энэ районы эдийн засаг төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд өмч хувьчлалын дараа үүссэн тархай, бутархай амины мал аж ахуй зонхилдог.

Долоо. Байгаль орчины талаар баримтлах бодлого

Тус компани нь байгаль орчиныг хамгаалах талаар дараах зарчмуудыг баримталж ажиллана. Үүнд

7.1 Судалгаа хийж байгаа талбайнхаа ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, түүнийг бохирдохоос сэрэмжилнэ.

7.2 Эргүүлэн ашиглах боломжгүй бүх төрлийн хог хаягдлыг Ханбогд сумын засаг даргаас 2003 онд авсан хог хаягдлын цэг байгуулах зөвшөөрөлийн дагуу байгуулсан шинэ хог хаягдлын цэг нийт 4000м² талбайд хог хаягдлуудыг төрөлжүүлэн хаяж булна.

7.3 Худаг, булаг шанд болон усан хангамжийн бүх эх үүсвэрийг бохирдохоос хамгаална.

7.4 Тээврийн бүх хэрэгслэлийг тусгайлан бэлтгэсэн газар зогсоож, тос шатахуун асгахаас сэргийлнэ.

7.5 Байр болон судалгааны талбайд хяналтгүй гал гарахаас сэрэмжилж гал түймрээс болгоомжилно. Гал түймрээс сэргийлэхтэй холбогдсон, дагаж мөрдөх дүрэм журмыг ОТ анги дээр цуглуулан холбогдох хүмүүсээр судлуулж түүнийг хэрэгжүүлнэ.

7.6 Уулын малталтаас гарсан 37000 м³ хуулагдсан хөрсний өнгөн хөрсийг урьдчилан хуулж, сүүлд нь нөхөн сэргээлтэнд ашиглахын тулд тусад нь тавина. Малталтын хажууд, газар зүйн дараах координатын байрлалд N- 4.766300, E-651,200 байх ба энэ нь далд уурхайгаас зүүн тийш 2 км – ийн зайд байрлана.

5 м өндөртэй 90м урт, 90м өргөнтэй овоолго хийж, түүнийг бүрхэх 8100 м² талбайг 10 см - ийн зузаантай 810 м³ буталсан чулуугаар бүрхэж, тоос шороо босохоос хамгаална.

7,7 Нийт 132768 м³ хаягдал усыг /зөвхөн шүршүүр болон угаалгын газрын хаягдал ус / тоосжилтыг ангиудын хоорон дахь зам дагуу цацаж байна.

7,8 Түүх ,архелогийн судалгаа үргэлжлүүлэн хийж цаашид үнэт олдвор байвал тэднийг хамгаалалтанд авна.

7.9 Байгаль орчины асуудлаар орон нутгийн захиргаа ,олон нийтийн байгууллагатай нягт хамтран ажиллаж , төлөвлөгөө боловсруулан орон нутгийн захиргаа, холбогдох албаар батлуулан түүнийгээ мөрдөж ажиллана.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын байгаль орчиныг хамгаалах тухай хууль, компанийн баримталж байгаа бодлого, Эко трейд компаниас боловсруулсан байгаль орчины ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайлангуудыг ашиглав.

Оюутолгой ордын байгаль орчинг хамгаалах арга хэмжээний

2004 оны төлөвлөгөө

№	Ажлын нэр	Хийх хугацаа	Хариуцах эзэн
1	Байгаль орчины төлөвлөгөөний 2004 оны тайланг бичих	12-р сард	Оюу толгой дахь БОинженер
2	БО-ны2004оны төлөвлөгөөг боловсруулж холбогдох газруудаар батлуулах	1-р сар	Улаанбаатар дахь БО-ны инженер
3	БОрчны нарийвчилсан үнэлгээгдүүсгаж тайланг батлуулах	4-р сар	Экотрейд компани, Айвенхое-гийн БОрчины инженерүүд
4	Зумпыг булаах	жилдээ	Холбогдох инженерүүд
5	Орчныг тоосжилтаас хамгаалж,карьер,отвалын замуудад усалгаа хийх	Тогтмол	Уулын инженер
6	Малталтаас гарсан хадыг зам дээр буталж тавих	6,7,8,9,10,11 саруудад	Уулын мастер
7	Овоолгын өнгөн хөрсийг чулуугаар дарж нөхөн сэргээх	Жилдээ	Байгаль орчины Мэргэжилтэн
8	Отвалыг засаж бульдозероор түрэх	Жилдээ	Байгаль орчины мэргэжилтэн ,уулын Инженер,ажилчид

2. ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТҮВШИНД МАЛТАЛТ ХИЙХ АЖЛЫН БАЙГАЛЬ ОРЧИНГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ерөнхий хэсэг

Төлөвлөгөөний гол зорилго нь Оюу Толгойд налуу ам нэвтрэх хайгуулын ажил нь Айвенхое майнз компанийн хайгуулын ажлын байгаль орчины бодлого, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагуудыг биелүүлэх явдал юм.

Энэ төлөвлөгөө нь налуу амны ажил гүйцэтгэхэд байгаль орчныг хамгаалах аргууд, орчны менежмент явуулах зааварчилгаа болно.

Энэ төлөвлөгөө нь Оюу толгойн талбайд 2004 онд налуу ам малталтын үргэлжлэлийг хийх хийх, байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө ба Оюу Толгойн лицензийн талбай дахь налуу ам нэвтрэх ажлаас үүдэн гарах болзошгүй нөлөөллийг тусгайлан зааж байгаа юм.

Өнөөдрийг хүртэл хийсэн хайгуулын ажлын хүрээнд гадаргын өрөмдлөгийг гүйцэтгээд байгаа боловч Айвенхоу цаашид газар доорх малталт хайгуулын ажил хийх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрээд байна.

Энэхүү газар доорхи ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

- Том хэмжээний технологийн дээж авч, хүдрийн баяжуулах чанарыг тодорхойлох
- Нөөцийг ангилалыг урьдчилсан байдлаас баталгаат хэмжээнд хүртэл өсгөж нарийн тогтоох зорилготой геологи хайгуулын өрөмдлөгийн ажил,
- Нарийвчлал бүхий ордын геологийн зураглал,
- Нэгэнт хийгдэж эхэлсэн геотехникийн загварчлалыг дахин шалгаж бүрмөсөн дуусгах үүднээс чулуулгийн геотехникийн бүрэн мэдээллийг цуглуулах,
- Уурхайн төлөвлөгөө болон сонгож авсан олборлолтын аргын тохиромжтой эсэхэд үнэлгээ өгөх зорилгоор мэдээ материалыг цуглуулах,

Хюго Зүүн хүдрийн биетэд явуулах энэхүү газар доорх ажлыг гүйцэтгэхэдээ хажуугийн малталтыг хийхээр төлөвлөж байна. Малталтын дүнд дээр дурдсан мэдээллүүдийг олж авахаас гадна хүдрийн биетэд хүрэх боломжийг өгөх ба ингэснээр цаг хугацааны хувьд уурхайн ажиллагааг малталт хийлгүйгээр эхэлснээс эрт эхлэх боломжтой болох юм.

Байгаль орчинд -д үзүүлэх нөлөөлөл нь бохирдлыг бууруулах, сэргийлэх, газар эвдэгдэх ажлыг бодит нөхцөл байдалд тохируулан багасгах, зорилгоор тодорхойлж, үнэлж, бууруулж зохицуулагдсан болно.

Хайгуулын ажлын явцад газар эвдэгдэхэд хүрвэл Компанийн зүгээс тухайн газрыг нөхөн сэргээх, хадгалах, бүх холбогдох арга хэмжээ авах болно.

Геологийн судалгааны ажил нь Монголын ашигт малтмалын тухай болон газрын хэвлийн тухай хуулиар зохицуулагддаг. Хуулийн заалтуудыг нарийвчлан судалж, төлөвлөгөөг боловсруулахдаа удирдлага болгосон болно.

1. Газрын дорх судалгааны ажлын зорилго

Энэхүү малталтын ажил нь дараах хоёр гол зорилгын үүднээс хийгдэж байгаа болно.

1. Мэдээллээ зузаатгах .

-Геологийн структурын мэдээллийг газар доорх өрөмдлөгийн ажлын үр дүнгээс олж авна.

-Геологийн агуулгын талаарх мэдээллийг багц дээжлэлт авч түүнийгээ интерполяцийн тайлал хийсэн өрмийн дээжийн агуулгатай харьцуулж гаргаж авна.

-Газар доорхи зураглал болон өрмийн ажлын дүнд геотехникийн мэдээллийг авна.

-Чулуулгыг макро түвшинд судалсанаар ашиглалтын аргын талаарх мэдээллээ нэмнэ.

-Багц дээжлэлтээр металлургийн гарцын мэдээллээ зузаатгана.

- Оюу Толгой нь ордын хувьд боломжтой эдийн засгийн хувьд боломжтой эдийн засгийн хувьд ашигтай орд гэдгийг тодорхойлж үзүүлэх ерөнхий мэдээллийг олж авна.

2. Ордод хүрэх боломжийг өгөх ба ингэснээр цаг хугацааны хувьд хүдрийн биетийн олборлолтыг малталт хийлгүйгээр эхэлснээс эрт эхлэх боломжтой болох юм.

2. ХУУЛЬ ТОГТООМЖ

Газар доорх бүх үйл ажиллагаанд Монгол улсын Далд уурхайд ажиллах дүрэм журмыг хамгийн наад захын ерөнхий стандарт болгон баримтлана. Харин газар доорх үйл ажиллагаа явагдаж буй талбайнуудад илүү нарийн тодорхой заалт бүхий журмыг баримтлах нь зөв гэж тус компани үзээд үүнд Баруун Австралийн Уурхайн Хөдөлмөр Хамгаалал Аюулгүй ажиллагааны журмыг баримталж ажиллана.

3. НАЛУУ МАЛТАЛТЫН ХЭМЖЭЭ

Газар доорх болон гадарга дээрх бүх тулгуур тоноглолыг хийсний дараах эцсийн байдлаар тогтоосон Оюу Толгойн хажуугийн малталтын бодит хэмжээ нь 5,5 м өргөн , 6 м өндөртэй байна.

5,5м – ийн өргөн нь 50 тн –ын даацтай ачааны тэргийг ашиглах бөгөөд нийт эзлэх зай нь 1,8 м байна. 6м – ийн өндөр нь 50 тн даацтай ачааны машиныг 1400мм агааржуулалтын сав суулгасан өрөөнд түүнийг шүргэхгүй ашиглах боломжтой болгож байна. Малталтаас гарсан 25000м³ хуулагдсан хөрсний өнгөн хөрсийг сүүлд нь нөхөн сэргээлтэд ашиглахын тулд тусад нь тавих ба малталтын хажууд 15 м өндөртэй 109м урт өргөнтэй овоолго хийж , овоолгын өнгөн хөрсийг тэгшлэн нөхөн сэргээж ургамалжуулна.

4. БОСОО МАЛТАЛТ

Хэрэв босоо малталт малталт энэ нь ойролцоогоор 520 м-ийн гүнтэй 8,1 м-ийн диаметртай байх ба 25000м³ хөрс шороо гарах ба энэ нь сийрэгжилтийн коэффициентээр шилжүүлэн тооцоход 37000 м³ шороо болох юм.

Уг босоо малталт нь 66Х хайгуулын лицензийн талбайд газар зүйн N 4.766300, E- 651,200 координатад байрлах ба босоо малталтаас зүүн тийш 2 км – ын зайд овоолго байна.

Овоолгын өндөр нь 5м урт 90м , өргөн 90м , 41500м³ эзэлхүүнтэй байх ба овоолгын 8100,0м² талбайг 10 см- ын зузаантайгаар 810,0 м³ буталсан чулуугаар бүрхэнэ.

5. УСАН ХАНГАМЖ


Техникийн усыг өрмийн ажил хийж буй газруудад тоос шороог дарах зорилгоор цооногийг усаар хангана. Ус дамжуулах шугам нь 110мм HDPE бүхий хоолой байна. Даралт тохируулагчийг босоо интервалаар байрлуулах ба энэ нь даралтыг хянаж түүнийг 300-1000 кра хооронд барьж байх юм. Газрын гүний усыг авч үйл ажиллагаандаа ашигладаг. Усны дундаж хурд нь 4 л/с – ээс бага байна.

Хянасан



Байгаль орчины ахлах инженер
Chris Serginson

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН



Байгаль орчины инженер Н. Туяа

2004.

ГАРЧИГ

Ерөнхиймэдээлэл.....	1
1,2 Төслийн зорилго.....	2
1,3 Төслийн эцсийн бүтээгдэхүүн	
1,4 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	
1,5 Тоног төхөөрөмж / үндсэн /.....	2
2,0 Эдийн засгийн үзүүлэлтүүд.....	3
Гурав. Төслийн үйл ажиллагаа,техниойн шийдлийн асуудал.....	.3
Дөрөв . Хог хаягдлын хяналт удирдлага зохион байгуулалт.....	.4
Тав Нийгмийн асуудал.....	.5
Зургаа Төсөл хэрэгжих газар нутгийн суурь нөхцөл байдал.....	6
Долоо Байгаль орчины талаар баримтлах бодлого6
Геологийн судалгааны түвшинд малталт хийх ажлын БОХ төлөвлөгөө10
1.Газрын дорх судалгааны ажлын зорилго	
Хуультогтоомж.....	.11
Хавсралт, Усны цооногийн судалгаа	